

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Цэцэгхайрхан ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/064/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал
Утас: Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ud@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.05.05 № 770
тамай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ЦЭЦЭГ ХАЙРХАН
ӨЭМТ-ИЙН ДАРГА С.ОЮУНЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нэг иргэнд ногдох санхүүжилт болон 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилт 939.0 сая төгрөг, хүүний орлого 0.1 сая төгрөг, үнэ төлбөргүй авсан хөрөнгийн орлого 103.3 сая төгрөг, бусад орлого 26.1 сая төгрөг, нийт 1,068.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,016.0 сая төгрөгийн зардал гаргаж, 52.5 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна. Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

1426050859

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/47 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтийг 95.7 хувь буюу хангалттай гэж үнэлэн 2026 оны гэрээг нэг жилийн хугацаатай байгуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

Хоёр.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,052,615.93	928,554.17
1.1.4	Бусад авлага	71,095,711.00	11,995,019.20
1.1.6	Бараа материал	91,606,849.01	104,502,781.40
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	165,755,175.94	117,426,354.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	119,854,530.42	221,234,941.00
1.2.2	Биет бус хөрөнгө	6,846,216.69	5,286,416.73
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	126,700,747.11	226,521,357.73
1.3	НИЙТ ХӨРӨНГӨ	292,455,923.05	343,947,712.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	-
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	93,544,569.00	93,544,569.00
2.3.2	Хувийн өмч	240,000.00	250,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	198,671,354.05	250,153,143.50
2.3.20	Эздийн өмчийн дүн	292,455,923.05	343,947,712.50
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	292,455,923.05	343,947,712.50

Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	984,179,924.83	938,995,795.00
3	Борлуулалтын өртөг	-	-
4	Нийт ашиг (алдагдал)	984,179,924.83	938,995,795.00
6	Хүүгийн орлого	108,872.30	100,397.25
9	Бусад орлого	70,427,240.09	129,405,001.29
11	Ерөнхий ба удирдлагын зардал	962,602,452.30	1,015,957,591.56
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	92,113,584.92	52,543,601.98
20	Орлогын татварын зардал	-	-
21	Татварын дараах ашиг (алдагдал)	92,113,584.92	52,543,601.98
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	92,113,584.92	52,543,601.98
28	Орлогын нийт дүн	92,113,584.92	52,543,601.98

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	93,684,569.00	106,647,769.13	200,332,338.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(90,000.00)	(90,000.00)
3	Залруулсан үлдэгдэл	93,684,569.00	106,557,769.13	200,242,338.13
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		92,113,584.92	92,113,584.92
6	Өмчид гарсан өөрчлөлт	100,000.00		100,000.00
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	93,784,569.00	198,671,354.05	292,455,923.05
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		(1,061,812.53)	(1,061,812.53)
11	Залруулсан үлдэгдэл	93,784,569.00	197,609,541.52	291,394,110.52
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		52,543,601.98	52,543,601.98
14	Өмчид гарсан өөрчлөлт	10,000.00		10,000.00
	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	93,794,569.00	250,153,143.50	343,947,712.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	938,618,303.13	1,010,877,855.05
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	938,509,430.83	1,010,777,457.80
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	108,872.30	100,397.25
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	924,663,805.87	994,582,016.81
1.2.1	Ажиллагчдад төлсөн	664,937,121.87	681,763,898.59
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,605,124.65	77,681,569.86
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	23,977,260.00	49,991,231.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	12,393,048.00	9,990,429.44
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,000,000.00	3,656,600.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	142,751,251.35	171,498,287.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,954,497.26	16,295,838.24
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,719,900.00	18,429,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,719,900.00	18,429,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(15,719,900.00)	(18,429,900.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,000.00	60,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,000.00	60,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	50,000.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		50,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,000.00	10,000.00
4	Валютын ханшийн зөрүү		
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,755,402.74)	(2,124,061.76)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,808,018.67	3,052,615.93
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,052,615.93	928,554.17

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа¹ илрээгүй.

Аудитаар нийт 5,674.5 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сонгинохайрхан дүүргийн Цэцэг хайрхан ӨЭМТ-ийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Татварын цахим системд тайлант онд худалдан авсан 4 харилцагчийн 5,674.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний и баримт бүртгэгдээгүй байна.	1	5,674.5					1	5,674.5				
	Дүн	1	5,674.5					1	5,674.5				

4.2. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
1	Шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас давсан 24,150.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг 1 аж ахуйн нэгжээс шууд худалдан авсан байна.	1	24,150.0							1	24,150.0		
	Дүн	1	24,150.0							1	24,150.0		